

**МОНГОЛД АРДЧИЛАЛ  
ЭЖЭЛСЭН**

**ТҮҮХ**

**HOW DEMOCRACY  
WAS BORN IN  
MONGOLIA**







**МОНГОЛД АРДЧИЛАЛ ЭХЭЛСЭН**

**ТҮҮХ**

**HOW DEMOCRACY  
WAS BORN IN MONGOLIA**

**2015 ОН**

## МОНГОЛД АРДЧИЛАЛ ЭХЭЛСЭН

### ТҮҮХ

## HOW DEMOCRACY

### WAS BORN IN MONGOLIA

**Гэрэл зургийг:** С.Амарсанаа, С.Цацралт, Питер Чарльзворт,  
Т.Энхболд, Р.Даваажав болон МоАХ–ны архив

**Зургийн  
тайлбарыг:** С.Амарсанаа, Ц.Майдар, Д.Халиун

**Редактор:** С.Баяраа, Б.Берт–Ужин, Ашлэй Вэйлэн

**Дизайнер:** Б.Боорчи

**Photos courtesy of:** S.Amarsanaa, S.Tsatsralt, Peter Charlesworth,  
T.Enkhbold, R.Davaajav, and Mongolian Democratic  
Union Archive

**Writers:** S.Amarsanaa, Ts.Maidar and D.Khaliun

**Editors:** S.Bayaraa, B.Burt–Ujin and Ashleigh Whelan

**Designer:** B.Boorchi

Copyright © Зориг сан болон Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн  
Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно.  
Улаанбаатар 2015 он

*Энэхүү цомгийг АНУ–ын Ардчиллын Төлөө Үндэсний Сангийн гэмжлэгтэйгээр  
хэвлэлээ. Цомогт илэрхийлсэн үзэл санаанууг нь уг сангийн албан ёсны байр  
суурь биш болно.*

“Мөнхийн Үсэг” ХХК–д хэвлэв.

Copyright © Zorig Foundation and International Republican Institute.  
All rights reserved.  
Ulaanbaatar 2015

*This publication was made possible through the support provided by the National  
Endowment for Democracy. The opinions expressed herein are those of the authors  
and do not necessarily reflect the views of the National Endowment for Democracy.*

Published at Munkhiin Useg LLC.

## ӨМНӨХ ҮТ

Энэ 7 дугаар сард Цагаан морин жилийн Ардчилсан хувьсгалын нэгэн томоохон түүхэн үйл явдал болох анхны ардчилсан сонгуулийн 25 жилийн ой тохиож байна.

Монголчууд бид тэртээ 1990 оны 7 дугаар сарын 22-29-нд анхны чөлөөт ардчилсан сонгуульдаа оролцож төрийн эрх барих дээд байгууллагаа өөрсдөө сонгосон билээ.

Үүнээс өмнөх сонгуулиудад сонгогчид нэг намаас нэр дэвшсэн нэг нэр дэвшигчийн төлөө албан журмаар саналаа өгдөг байсан бол 1990 онд анх удаагаа олон намаас нэрийг нь дэвшүүлсэн олон нэр дэвшигчийн дундаас сонголтоо хийсэн юм. Шинэ намууд далан жил төр засаг барьсан намтай, шинэ залуучууд хэвлэл мэдээлэл, мөнгө санхүү, техник хэрэгсэл, албан тушаал зэрэг нийгэмд нөлөөлөх бүхнийг өмчилсөн эрх баригчидтай хүч тэнцвэргүй өрсөлдсөн ч байнгын ажиллагаатай парламент Улсын бага хуралд 40 хувийн суудал авч байв.

Энэ түүхэн үйл явдал өөрөө аяндаа бий болчихоогүй юм. Төрийн эрх барих дээд байгууллагын сонгуулийг хугацаанаас нь өмнө явуулах зорилт бол 1989 оны 12 дугаар сарын 10-нд эхэлсэн Цагаан морин жилийн Ардчилсан хувьсгалын нэг гол шаардлага нь байв. Анхны чөлөөт ардчилсан сонгууль бол 8 сар үргэлжилсэн тэмцлийн үр дүн, манлайлсан, идэвхийлэн оролцсон, дэмжсэн олон арван мянган хүний эр зориг, сэтгэл зүтгэлийн үр дүн, тэмцэж олсон эрх чөлөөгөө мэдэрсэн онцгой баярт үйл явдал байв.

Зориг сан, АНУ-ын Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнтэй хамтран энэ ойд зориулан Ардчилсан хувьсгалын гол үйл явдлууд хэрхэн өрнөж, монголчууд ардчилсан хувьсгалдаа хэрхэн оролцсоныг эргэн дурсаж, гэрэл зурагт мөнхөрсөн түүхийн ховор агшнуудыг дэлгэн үзүүлэх зорилгоор энэхүү цомгийг эмхэтгэлээ.

## INTRODUCTION

Twenty-five years ago, in July 1990, Mongolia held its first democratic, free and fair elections - one of the most significant milestones in the democracy movement that started on a freezing December day in 1989. For our country, it was strange and new experience after many elections where there was always a single candidate from a single party and mandatory participation. For the first time we were free to choose between several candidates from different political parties or to choose not to participate at all. There were four parties elected to the new Parliament, including three that were newly formed during the democracy movement. These new parties won 40% of seats in the Small Hural (lower chamber) – the first full-time legislature in Mongolia.

Power sharing between the new parties and the incumbent party was a real challenge but the transition was peaceful and governing a new democracy, while challenging, was a joint effort.

Free elections didn't come easily to Mongolia. From first rally of democracy fighters, and ultimately supported by tens of thousands of people from all corners of Mongolia, it took eight long months to make the demand for early, democratic elections to happen.

This book will show you how Mongolian democracy was born, who were its main actors and how they were able to lead political forces and people through peaceful but dramatic confrontation to a transition from authoritarian rule to competitive, multi-party democracy.

We, the Zorig Foundation and International Republican Institute, felt obliged that after 25 years, the Mongolian democracy movement should be remembered and celebrated by the people of Mongolia and other countries and made known to young Mongolians who will make this country even more free and democratic, happy and prosperous.

*“Ардчилсан хувьсгал монголчуудад хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, зах зээлийн харилцаа, үг хэлэх хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, сүсэглэн бишрэх, амьдран суугаа газраа чөлөөтэй сонгох, гадаадад зорчих, хүссэн мэргэжлээрээ хүссэн улс орондоо суралцах зэрэг хүний наад захын эрхийг олгосон юм.*

*Ардчилсан хувьсгалын хамгийн гол ололт, үнэ цэнэ нь сүүлийн 300 шахам жилийн гадаад улсын хараат байдлаас гарч Монгол улс төрийн тусгаар тогтнолоо жинхэнэ утгаар нь олж, хувь заяагаа монголчууд өөрсдөө шийдэх болсон явдал байлаа.”*

*Б.Батбаяр (Баабар)*

*“The democratic revolution enabled Mongolians to have individual human rights and freedoms such as private property, a market economy, freedom of expression and freedom of the press, freedom of assembly and religion, the right to freely choose where to live and when to travel abroad and the right to choose study any subject.*

*But the biggest achievement of the democratic revolution was that Mongolia gained independence from almost 300 years of foreign control, became truly sovereign and enabled the right to self determination to define its destiny.”*

*B.Batbayar (Baabar)*

---

**1989.12.10**

---

**1992.01.13**

---



1989 оны 12 дугаар сарын 10-нд Монголын Ардчилсан Холбоо анхны цуглаанаа хийж олон намын систем тогтоох, хүний эрхийг дээдлэх, бүх нийтийн сонгуулийг хугацаанаас нь өмнө 1990 оны эхний хагаст багтаан явуулах, хэлмэгдэгсдийг цагаатгах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаатай болгох зэрэг 13 зүйлийн шаардлага тавьснаар Монголд ардчилсан хувьсгал эхэлснийг зарлан тунхаглалаа.

The first rally of the Mongolian Democratic Union (MDU) was held on International Human Rights Day - December 10, 1989 at the front entrance of Youth Cultural Center. Attended by 300 people, this event marked the beginning of the democratic revolution in Mongolia after almost 70 years of communist rule.





Анх удаа зөвшөөрөлгүй гадаа хийсэн энэ цуглаанд 300 шахам хүн сайн дураараа ирж оролцсон юм. Цуглааны үеэр “Хонх” хамтлагийн уран бүтээлч С.Цогтсайхан, Н.Энхбаяр хоёр алдарт “Хонхны дуу”-гаа дуулсан нь ардчилсан хувьсгалын сүлд дуу болсон билээ. “Хонхны дуу биднийг сэрээ, сэрээ, Хонхны дуу зоригийг бадраа...”

Once encouraged by Soviet perestroika but disappointed by Mongolian People’s Revolutionary Party’s (MPRP) slow pace of reforms, several dissident groups came together to form the first informal democratic movement. The first statement of the MDU demanded that the communist state introduce a multi-party system and full-time parliament as well as respect the principles of the Universal Declaration of Human Rights. The MDU also called for free and fair elections, which to be held within a year, freedom of the press, and recognition of past political repressions.

Journalists S.Tsogtsaikhan and N.Enkhbayar performed their “Song of the Bell” that called people to wake up and have courage. The song emerged as a hymn of the democratic revolution.



Цуглаанд оролцогчид “Олон намын систем,” “Эрх зүйт төрийн төлөө,” “Хүний эрхийг эрхэмлэн дээдэлъе,” “Хэвлэлийн эрх чөлөө” зэрэг уриа лоозонгууд барьж МоАХ-ны шаардлагуудыг уухайлан дэмжиж байв.

Demonstrators holding slogans “Multi-party system,” “Rule of Law,” “Human Rights,” and “Free Press.”



МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн С.Зориг, Д.Нинж, “Хонхны дуу” хамтлагийн ахлагч, сэтгүүлч С.Цогтсайхан нар анхны цуглаан дээр.

MDU Coordinating Council members S.Zorig, D.Ninj and journalist and singer of the revolutionary hymn song S.Tsogtsaikhan at the first MDU rally.

МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн Гандан хийдийн голч лам Д.Баасан лам хувцастайгаа цуглаанд оролцож сүсэглэн бишрэх эрх чөлөөг сэргээх, уламжлалт шашин, соёл, ёс заншил, түүхийн үнэнийг сэргээх шаардлага тавьсан билээ.

Buddhist monk D.Baasan, MDU Coordinating Council member, joined the rally in his monastic dress, demanded freedom of religion and the revival of celebrating Mongolian history and cultural traditions.





Дуурь бүжгийн театрын өмнө хийсэн 1989 оны 12 дугаар сарын 17 -ны цуглаан дээр “Айвал бүү хий, хийвэл бүү ай,” “Шинэ цаг ирлээ, сэрцгээ,” 1 сарын 14 -ний цуглаан дээр “Монголчуудаа мориндоо,” “Зээлийн социализмыг халъя,” 2 сарын 11-ний цуглаан дээр “Цэдэнбалыг ард түмний шүүхэд,” “Тусгай халамжийг халъя” зэрэг олон уриа лоозон нэмэгдсэн нь залуучуудыг зоригжуулж байв.

After December 10, 1989 rallies attracted an increasing number of people every weekend at central locations in Ulaanbaatar, moving closer to the main square (now Chinggis Khaan Square) where Government is headquartered. Rallies displayed slogans “New times have come, wake up!” “Mongolians get on your horses,” “Truth will not be revealed if truth is concealed” (this slogan was written using traditional Mongolian script that was replaced by Cyrillic in 1940s).



Улс төрийн шаардлагуудыг нь нам, төрийн удирдлага хүлээж авахгүй байсан тул МоАХ 4 дэх цуглаанаа 1990 оны 1 дүгээр сарын 21-нд нийслэлийнхээ төв талбайд зохион байгуулсан юм. Энэ цуглаан дээр МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг “МАХН нийгмийн удирдан чиглүүлэгч хүч мөн” гэсэн томъёоллыг Үндсэн хуулиас хасахыг дахин шаардав. Үг хэлсэн хүмүүс хэвлэлийн эрх чөлөөг шаардаж, МАХН-ын хэмжээгүй эрхийг эсэргүүцэж байлаа.

Leader of the Mongolian Democratic Union Sanjaasurengiin Zorig speaking at the big rally (January 21, 1990) held at the main square. In his speech Zorig repeated MDU's demand that the Constitutional provision about the Mongolian People's Revolutionary Party being a major force in the society be removed.



Ж.Мөнхбат аварга энэ цуглаанд оролцож ардчиллын төлөө олон түмний тайван тэмцэлд сэтгэл санааны дэмжлэг үзүүллээ.

Famous Mongolian national wrestling champion J.Munkhbat cheering up the demonstrators.



Тэгсгэм өвлийн хүйтнийг үл хайхран 20 гаруй мянган хүн 4 дэх цуглаанд оролцсон нь анхны цуглаанд оролцогчдын тооноос даруй 100 дахин их байв. Цуглааны ажиллагааг сурвалжлахын тулд БНХАУ-ын нийслэл Бээжинд суурин ажилладаг гадаадын томоохон хэвлэлүүдийн сурвалжлагчид жуулчны визээр манай улсад ирсэн байв.

Harsh winter cold did not stop 20,000 people from gathering for the fourth rally. Foreign correspondents accredited to Beijing started coming to Mongolia on tourist visas to cover the events.



Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас цуглаан хийх зөвшөөрөл өгөөгүй ч МоАХ-ны салбар зөвлөлийн гишүүд талбайн 4 талаас нь жагсан орж ирээд Д.Сүхбаатарын хөшөөний өмнө хийсэн энэ цуглаан дээр Ардчилсан социалист хөдөлгөөн үүсэн байгуулагдсаныг тус хөдөлгөөний удирдагчдын нэг Д.Ламжав олон түмэнд мэдэгдэж ардчиллын төлөө тэмцэлд нэгдэж буйгаа илэрхийлсэн юм.

Despite repeated refusal from the Ulaanbaatar city council to hold a peaceful demonstration, MDU members marched towards the main square from all four sides. Mr. D.Lamjav declared the formation of the second democratic force-Mongolian Democratic Socialist Movement.



Анхдугаар их хурлын үндсэн илтгэлийг МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн Д.Сосорбарам уншив. Монголын 16 аймаг, 3 хотоос 611 төлөөлөгч, 200 зочин их хуралд оролцсоноос гадна виз олгоогүй тул аялагч жуулчны дүрээр гадаадын 30 гаруй сэтгүүлч ирж сурвалжилсан юм.

MDU Coordinating Council member D.Sosorbaram speaking at the First Congress. 611 delegates from 16 provinces and three major cities of Mongolia participated in the MDU Congress. In addition, 200 guests and more than 30 foreign reporters attended the event.

1990 оны 2 дугаар сарын 18-нд улс орны өнцөг булан бүрээс төлөөлөгч ирж оролцсон МоАХ-ны анхдугаар их хурал амжилттай болж, энэ хурал дээр Монголын ардчилсан нам байгуулагдсанаа зарласнаар олон намын тогтолцооны эхлэлийг тавьлаа.

The First Congress of the MDU with delegates from all provinces of Mongolia declared the emergence of Mongolian Democratic Party, marking the beginning of a multiparty system.





МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг анхдугаар хурал дээр үг хэлж их хурлаас гаргасан мэдэгдлүүдийг уншиж сонордуулав. Их хурлаас сайд нарын зөвлөлийг огцруулж ардын их хурлыг тараах шаардлага тавьсан юм.

General Coordinator S.Zorig made statements on behalf of the MDU demanding resignation of the Cabinet of Ministers and dissolution of the People's Great Hural (Parliament).

Олон түмэн Ардчиллын төлөө тайван тэмцэлд босч цуглаан, жагсаалууд эрч хүчээ авч өргөн олон түмнийг хамрахын хамт эрх баригчдын хатуу хориг улам бүр суларч байлаа. МоАХ-ны гишүүд дэмжигчид анхдугаар их хурлынхаа ажиллагааг телевиз, радиогоор орон даяар шууд дамжуулахыг шаардаж замын хөдөлгөөн хаасны үр дүнд олон нийт хурал дээр дэвшүүлсэн шинэ санаануудыг сонсож, ардчилал эрх чөлөөний уур амьсгалыг үзэж мэдрэх боломж гарсан юм.

Under the pressure of fast growing demonstrations supported by an increasing number of people, the government eased its restrictions. When the demonstrators blocked traffic on main streets, the government allowed a live broadcast of the First Congress of the MDU, held on February 18, 1990.







МоАХ-ны Ерөнхий зохицуулах зөвлөлийн зарим гишүүд хурлын дараа. Арын эгнээ зүүн гар талаас: Ц.Элбэгдорж, А.Мурат, И.Жавхлант, Э.Бат-Үүл, Г.Бошигт, Б.Жаргалсайхан, П.Нэргүй, Х.Цэгмид, Б.Энхтүвшин, Д.Энхбаатар, Д.Болд, Д.Цолмон, Д.Дорлигжав, Д.Батзориг, Н.Гантөмөр, Д.Сүхбаатар, Д.Баасан, С.Амарсанаа, Б.Галсандорж, Б.Билэгт, Ч.Машбат, Д.Сосорбарам. Өвөр эгнээнд зүүн гар талаас: Я.Батсүх, С.Зориг, Л.Хадбаатар, Ц.Энхтүвшин, Б.Батцэнгэл, Л.Нямсүрэн, О.Очиржав, В.Энхболд, Д.Төмөр-Очир, З.Эрдэнэбат.

MDU Coordinating Council members (back row from left) Ts.Elbegdorj, A.Murat, I.Javkhlant, E.Bat-Uul, G.Boshigt, B.Jargalsaikhan, P.Nergui, Kh.Tsegmid, B.Enkhtuvshin, D.Enkhbaatar, D.Bold, D.Tsolmon, D.Dorligjav, D.Batzorig, N.Gantumur, D.Sukhbaatar, D.Baasan, S.Amarsanaa, B.Galsandorj, B.Bilegt, Ch.Mashbat, D.Sosorbaram, (front row from left) Ya.Batsukh, S.Zorig, L.Khadbaatar, Ts.Enkhtuvshin, B.Battsengel, L.Nyamsuren, O.Ochirjav, V.Enkhbold, D.Tumur-Ochir, and Z.Erdenebat.



Их хурал хуралдсан МҮЭ-ийн Соёлын төв ордны гадаа олон мянган хүн цугларч баяр хүргэж, амжилт хүсч байв.

Thousands of supporters gathered outside the Congress venue to congratulate the MDU.

Их хурлын баримт бичгүүд болон тайзны засал чимэглэлийг МоАХ-ны гишүүд өөрсдийнхөө нөөц бололцоог дайчлан хийж бэлтгэж байв. Төлөөлөгчдөд олгох мандатыг Н.Жаргалсайхан хариуцан нууц байдалд хэвлэсэн юм.

MDU members helped prepare documents for the Congress. N.Jargalsaikhan secretly made badges for the delegates.





Орон даяар байгуулагдсан МоАХ-ны салбар зөвлөлүүд төлөөлөгчдөө их хуралд оролцуулсан юм. Энэ өдөр “Монголын ард түмний чөлөөт хэвлэл” гэсэн тодотголтойгоор төр, засгийн хяналтаас хараат бус анхны хэвлэл болох “Шинэ толь” сонины эхний дугаар гарчээ.

MDU branches set up across the country sent their delegates to the Congress. On this day the first issue of the first independent newspaper “The New Mirror” was published.



МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн, зөвлөх доктор П.Нэргүй болон Г.Бошигт, Д.Энхбаатар, С.Зориг нар хурлын дараа хэвлэл мэдээллийнхэнтэй уулзалт хийж асуултад нь хариуллаа.

MDU Coordinating Council members P.Nergui, G.Boshigt, D.Enkhbaatar and S.Zorig at a press conference following the Congress.

Их хурлын өмнөх өдрүүдэд МоАХ-ны чуулганууд Дугуй зааланд болж байлаа. Дугуй зааланд болсон нэгэн чуулганы үеэр.

Pre-convention meetings were held in so-called "Round Hall."





МоАХ улс төрийн шаардлагууддаа хариу нэхэж Ням гараг бүр цуглаан зохион байгуулж, түүнд оролцогчдын тоо олон арван мянган хүнээр тасралтгүй өсөн нэмэгдэж байлаа. Төр засгийн хатуу хяналтад байсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ үйл явдлын талаар огт мэдээлэхгүй байсан тул МоАХ тогтмол гаргадаг мэдээлэл, мэдэгдлүүдээ нийслэлийн бүх гудамжны дагуух гэрлийн шонгуудад наах, ухуулах хуудас тараах, их дээд сургуулиуд, үйлдвэр албан газруудад очиж уулзалт яриа хийх зэргээр үзэл санаагаа эрчимтэй түгээж байв. С.Зориг, Э.Бат-Үүл хоёр ажилчидтай уулзаж яриа хийхээр өглөө эрт хотын захын нэгэн үйлдвэр рүү дөхөж яваа нь.

MDU rallies were held every Sunday and the number of attendants steadily increased reaching thousands. State-controlled media were silent about those events, therefore MDU activists distributed leaflets, went to universities, factories and government offices to tell people about the democratic revolution. S.Zorig and E.Bat-Uul walking in the early morning to a factory on the outskirts of the city.



МоАХ-ны үйл ажиллагаанд зориулж иргэд хандив өргөж байлаа. МоАХ-ны гишүүн Р.Самбараазана цуглаан дээр хандивын хайрцаг аялуулж байна.

Many people were donating money to support the MDU. Activist R.Sambarazana walking a donation box during a rally.



Тухайн үеийн Монголын оюутны холбоо нь ардчиллын төлөө дөрвөн холбооны нэг нь болж цуглаан жагсаалуудад идэвхтэй оролцож байлаа.

Mongolian Students Union was one of the four pro-democracy unions, actively participating in protests.



100 шахам мянган хүн оролцсон 3 сарын 4-ний цуглаанд оролцогчид МоАХ-ны улс төрийн шаардлагуудад хариу өгөхийг болон намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлахыг шаардсан юм.

Nearly 100,000 people participated in the March 4 rally (population of the capital city Ulaanbaatar at that time was 590,000). Demonstrators demanded amendments in the election law and separation of party and state.



Цуглаанд оролцогчид Ялалт (одоогийн Тэнгис) кино театраас Засгийн газрын ордон хүртэл сүрт жагсаал хийж БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдэд шаардлага гардуулсан юм.

Protesters rallying at the Victory Cinema (now Tengis Cinema) marched towards the Government House and handed over their petition to the People's Great Hural (Parliament).





Дөрвөн холбооны хамтарсан жагсаал төрийн ордныг тойрон явж байна.

Joint rally of the "Four Forces."



Ардчиллын төлөөх 4 холбоо МоАХ, АСХ, ШДХ, МОХ-ны төлөөлөгчид шаардлагаа гардуулсны дараа.

Representatives of the "Four Forces" after submitting their petition to the government.



100 шахам мянган хүн оролцсон 3 сарын 4-ний цуглаанд оролцогчид МоАХ-ны улс төрийн шаардлагуудад хариу өгөхийг болон намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлахыг шаардсан юм.

Nearly 100,000 people participated in the March 4 rally (population of the capital city Ulaanbaatar at that time was 590,000). Demonstrators demanded election law and separation of party and state.



Эрх баригч МАХН, төрийн удирдлагын зүгээс 4 холбооны хамтарсан шаардлагад хариу өгөөгүй учир 1990 оны 3 дугаар сарын 7-нд МоАХ-ны ЕЗЗ-ийн 10 гишүүн нийслэлийн төв талбайд улс төрийн өлсгөлөн зарлав.

The government did not respond to the “Four Forces” joint petition, and therefore in the early morning of March 7, 1990 ten members of the Coordinating Council of MDU went on a hunger strike right in front of the Government House.



Улс төрийн өлсгөлөн зарлагчдын шаардлагыг эрх баригчид үл тоомсорлосон тул МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн Э.Бат-Уулийн санаачилгаар тэд МАХН-ын Улс төрийн товчоог бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохыг шаардаж амь насаараа дэнчин тавьж буйгаа мэдэгдсэн юм. Энэ тэмцлийг дэмжсэн олон түмний хөдөлгөөн орон даяар эрчимтэй өрнөж байлаа.

Authorities continued to ignore demands of hunger strikers. E.Bat-Uul, a member of the Coordinating Council of MDU, announced that protesters would fast unto death if MPRP Politburo did not resign. The public support for this fight had spread nationwide.



МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг, МоАХ-ны тэргүүлэгч гишүүн Ц.Элбэгдорж хоёр улс төрийн өлсгөлөнгийн үеэр зөвлөлдөж байна.

MDU General Coordinator S.Zorig and MDU Presidium member Ts.Elbegdorj during the hunger strike.

Ардчилсан хувьсгалын оргил үйл явдал болсон улс төрийн өлсгөлөн зарлах тэмцлийг монгол судлаач Финланд оюутан Ирьяа Халаш сурвалжлан Ройтерс агентлагт дамжуулж дэлхий ертөнцтэй холбож байв.

Finnish student Irya Halash who studied in Mongolia was a stringer with Reuters and delivered to the world a full report about the dramatic events in the country.





БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Д.Бямбасүрэн талбай дээр ирж улс төрийн өлсгөлөн зарлагчдын төлөөлөл МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн Э.Бат-Үүл болон МоАХ-ны Тэргүүлэгч гишүүн Ц.Элбэгдорж хоёртой уулзсанаар яриа хэлэлцээний эхлэлийг тавьлаа.

For the first time since the beginning the pro-democracy movement, the government sent its representative, Deputy Prime Minister D.Byambasuren, to negotiate with MDU leaders E.Bat-Uul and Ts.Elbegdorj.



МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн Гандан хийдийн голч лам Д.Баасан лам нараа уриалан дуудаж улс төрийн өлсгөлөн зарлагчдад ном уншиж, урам зоригийг нь дэмжиж байв.

MDU's Coordinating Council member and Gandan temple's monk D.Baasan and fellow monks offered prayers to hunger strikers.



Улс төрийн өлсгөлөнд оролцогчдын тоо нэмэгдсээр 9-ний өдөр 33 хүрсэн юм.

By March 9, the number of hunger strikers reached 33.

Улс төрийн өлсгөлөн зарлах тэмцэлд оролцсон ганц эмэгтэй Ш.Нина радиогийн сурвалжлагчид ярилцлага өгч байна.

Sh.Nina, the only female hunger striker, giving an interview to a state radio reporter.





МоАХ-ны гишүүд улс төрийн өлсгөлөн зарласан нийслэлийн төв талбай ардчилсан хувьсгалын төв нь болж дэмжигчид тасралтгүй цугларч, жагсаал, цуглаан, зэрэг олон үйл ажиллагаа өрнөж байв. Зураачид зурагт хуудас зурж байна.

During the hunger strike, capital city's main square became the center of the democratic revolution with thousands of supporters present at the site round the clock. Artists painting rally posters.

Улс төрийн өлсгөлөн зарлагчдын эргэн тойронд олон мянган дэмжигчид цугларч сэтгэл санааны дэмжлэгээ хүчтэй илэрхийлж байв. Заримдаа тэдний тоо олон арван мянгад хүрч байдал эгзэгтэй болж байлаа.

Hundreds of supporters were present day and night at the site of the hunger strike. At times their number reached tens of thousands, making it difficult for MDU activists to manage the crowd and ensure that it remained peaceful.







Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ардчиллыг дэмжигч эмэгтэйчүүд улс төрийн өлсгөлөн зарлагчдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэв.

Women lending their support to hunger strikers on International Women's Day.

Улс төрийн өлсгөлөнг Монголд жуулчны визээр ирсэн гадаадын сурвалжлагчид сурвалжилж мэдээ цацаж байв. Зураг дээр Японы NHK агентлагийн сурвалжлагчид газар дээрээс сурвалжилж байна.

Japan's NHK crew, who had to travel on tourist visas, reporting about the hunger strike.





БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, УТТ-ны гишүүн Ж.Батмөнх ард түмний тайван тэмцлийн эсрэг хэрхэвч хүч хэрэглэж болохгүй гэсэн хатуу байр суурьтай байсан нь ардчилсан хувьсгалыг нэг ч хүний хамраас цус урсгалгүй тайван өрнөхөд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм. Тэрээр төлөв төвшин зантай, аливаад хүлээцтэй уужуу тайван ханддаг хүн байв.

Leader of the ruling MPRP and Chairman of the People's Great Hural (Parliament) J. Batmunkh held a strong belief that no force should be used against the peaceful demonstration by the people. He played a crucial role for the democratic revolution to succeed without a single person being harmed during the protests.



МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг өндөр боловсролтой, төлөв төвшин зантай, аливаа хурцадмал асуудалд хүлээцтэй ханддаг, зөвшилцлийг эрхэмлэдэг хүн байсан нь тайван замаар хийсэн ардчилсан хувьсгалын амжилтад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Ж.Батмөнх, С.Зориг хоёрын зан төрх, байр суурь ижил байсан нь ардчилсан хувьсгал тайван замаар амжилтанд хүрэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Leader of the Mongolian democratic revolution, MDU General Coordinator S.Zorig was a well-educated and talented politician who preferred consensus building over confrontation both within the MDU and with the ruling MPRP. Leaders J.Batmunkh and S.Zorig played a critical role in ensuring Mongolia's transition to democracy remained peaceful and helping democratic changes take place in a short time.



Бурханы шашин өнө үүрд дэлгэрэх болтугай! Ийм уриан дор монголын сүсэгтнүүд 1990 оны 3 дугаар сарын 11-нд анх удаагаа цуглаан хийж сүсэг бишрэлийн эрх чөлөөгөө шаардлаа. Цуглаанд олон зуун сүсэгтэн өндөр настнууд, залуус, лам хуврагууд оролцож үгээ хэлж, мөргөл ном уншиж, буяны үйлст хандив өргөж, баярлаж сэтгэл хөдөлсөндөө нулимс дусааж байв.

“May Buddhism eternally flourish” was the motto of supporters of Buddhist religion who held their rally on March 11, 1990 to revive the freedom of religion in Mongolia. Hundreds of men and women, old and young, rallied, giving speeches, offering prayers and shedding tears of joy.



МАХН-ын Төв Хорооны 8 дугаар Бүгд хурал 3 дугаар сарын 12-14 нд болж Улс Төрийн Товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, намынхаа Онц их хурлыг 4 дүгээр сарын 10-нд хуралдуулахаар товлов.

MPRP's Politburo resigned during the party's Eighth Central Committee Conference held on March 12-14, 1990. The party decided to meet for its Extraordinary Congress on April 10.



Дарангуйлагч дэглэмийн бэлгэ тэмдэг болсон И.В.Сталины хөшөөг буулгаж байна.



Removal of the statue of Josef Stalin at the National Library entrance.



3-р сарын 8-нд радио телевизээр шууд хийсэн яриа хэлэлцээнд нэг талаас МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг өлсгөлөн зарлагчдын төлөөллийн хамт нөгөө талаас Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном, орлогч дарга Д.Бямбасүрэн нар оролцсон юм. Ийнхүү 8-9-нд үргэлжилсэн яриа хэлэлцээний үр дүнд талууд зөвшилцөлд хүрч нам төрийн тэргүүн Ж.Батмөнх МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээр огцрох болсныг мэдэгдсэнээр улс төрийн өлсгөлөн зогссон юм.

On March 8, MDU General Coordinator S.Zorig and representatives from the hunger strike met with government officials, Prime Minister D.Sodnom and Deputy Prime Minister D.Byambasuren at the Central TV studio. The meeting was aired on TV and radio. After another day of negotiations the hunger strike ended when MPRP leader J.Batmunkh agreed to resign along with all members of his Politburo.



Улс төрийн өлсгөлөн зарласан тэмцлийн үр дүнд эрх баригч нам, төр, засгийн удирдлагыг өөрчлөөд зогсоогүй монголын нийгэмд улс төрийн харилцааны шинэ соёл нэвтэрсэн юм. 3 дугаар сарын 10-нд улс төрийн нам холбоод хамтарсан мэдэгдэл гаргаж эх орон, улс үндэстнийхээ эв нэгдэл, эрх ашгийг эрхэмлэн дээдэлж тэгш эрхтэй байх, бие биенээ харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, нэг нэгнийхээ эсрэг хүч үл хэрэглэх зарчим баримтлах бөгөөд улс төрийн тулгамдсан асуудлаар харилцан зөвлөлдөж тохиролцоонд хүрэхийг эрмэлзэхээ зарлан тунхаглав.

A hunger strike, though an extreme political action, was necessary to cause the ruling party to resign, and it also brought a new culture of political negotiation to the society where no discussions were ever possible in the past. On March 10, 1990, all political parties and movements issued a joint statement to respect unity and interests of the nation, not interfere with internal affairs and restrain from using force against each other while seeking consensus in political disputes.







1990 оны 3 дугаар сарын 21-23 нд хуралдсан БНМАУ-ын АИХ-ын ээлжит бус 8 дугаар чуулган Үндсэн хуулиас: “БНМАУ-ын төр нийгмийн удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгосон МАХН мөн” гэсэн заалтыг хасав. Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж “...ард түмнийхээ язгуур эрх ашиг, эв нэгдэлд нийцсэн мөрийн хөтөлбөр, дүрэм бүхий улс төрийн нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх” эрхтэй гэсэн шинэ заалт нэмж баталжээ.

The now irrelevant provision about the Mongolian People's Revolutionary Party being a major force in the society was removed from the Constitution at the Extraordinary session of the People's Great Hural (Parliament) held on March 21-23. Parliament amended the basic law with the new provision stating that citizens have a right to join political parties and civil organizations.

Чуулганд шинэ нам холбоодын удирдлагыг урилгаар оролцууллаа. Түүнчлэн энэ чуулганаар нам төрийн удирдлагыг салгаж БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар П.Очирбатыг сонгож батлав. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Д.Содном өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөж Сайд нарын зөвлөлийн дарга буюу Ерөнхий сайдаар Ш.Гунгаадорж томилогдов.

One representative from each new party and movement was invited to attend the session. Parliament resolved that functions of political party should be separated from those of the state. P.Ochirbat was elected Chairman of the Parliament, and Sh.Gungaadorj as Prime Minister.





АИХ-ын чуулганд ажиглагчаар суусан С.Зориг Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан тухай мэдээ нөхөддөө дуулгаж байхад нь энэ зургийг даржээ.

S.Zorig calling his MDU fellows to tell about the new amendments to the Constitution.



Эрх баригч МАХН-ын Онц их хурал хуралдаж намынхаа удирдлагыг бүрэн бүрэлдэхүүнээр нь солив.

MPRP leadership was changed completely during its Extraordinary Congress.



1990 оны 3 дугаар сарын 21-23-нд хуралдсан БНМАУ-ын АИХ-ын ээлжит бус 8 дугаар чуулган Үндсэн хуулиас: “БНМАУ-ын төр нийгмийн удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгосон МАХН мөн” гэсэн заалтыг хассанаар нэг намын далан жил үргэлжилсэн ноёрхол төгсгөл болсон юм.

The provision about the Mongolian People’s Revolutionary Party being a major force in the society was removed from the Constitution at the Extraordinary session of the People’s Great Hural (Parliament) held on March 21-23.



МАХН-ын Төв хорооны 8 дугаар бүгд хурлаас 1960 –аад онд улс төрийн талаар хэлмэгдсэн төр, засгийн зүтгэлтэн Д.Төмөр-Очир асан, Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг болон тэдний бүлэгт элссэн хэмээн хэлмэгдсэн хүмүүсийг цагаатгав. Гэвч үүний цаана манай түүхийн туршид 1930 –аад оны их яргалалд өртөж амь насаа алдсан олон арван мянган гэм зэмгүй иргэдээ цагаатгах ажил орхигдсон юм.

The MPRP Conference held on March 12-13, 1990 rehabilitated victims of political repression of 1960s – statesmen D.Tumur-Ochir, Ts.Loohuuz, B.Nyambu, B.Surmaajav and their followers. But the party remained silent about tens of thousands of killings during the Stalinist-style repressions during the 1930s in Mongolia.



Монголд олон намын тогтолцооны үндэс суурийг тавьсан Монголын ардчилсан намын анхдугаар их хурал 1990 оны 4 дүгээр сарын 7-8-нд хуралдаж хүнийг дээдэлсэн ардчилсан нийгэм байгуулах зорилт бүхий мөрийн хөтөлбөр, дүрмээ батлав. Их хурлаас ардчилсан бүх нийтийн сонгууль явуулах, ардчилсан үндсэн хуулийг улс төрийн бүх хүчний оролцоотойгоор боловсруулах, хэвлэлийн эрх чөлөөг хангахыг эрх баригчдаас шаардсан юм.

Mongolian Democratic Party (MDP) held its first Congress on April 7-8, 1990. The party declared its platform aimed at building a democratic society for the sake of people. Participants of the meeting voiced their demand for calling general elections, drafting a new constitution with involvement of all political forces, and enabling freedom of the press.

МоАН-ын Чөлөөт их хурал тус намын Улс төрийн зөвлөлдөх төвийн Ерөнхий зохицуулагчаар Эрдэнийн Бат-Үүлийг сонгож батлав.

The MDP Congress elected E.Bat-Uul as its first Chairman.





“Ардчилал” сонины анхны дугаарыг худалдан авсан хүмүүс МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зоригт баяр хүргэж байна.

S.Zorig congratulated by first readers of “Democracy” newspaper.

1990 оны 4 дүгээр сарын 7-нд эрх баригч нам, төр засгийн хяналтаас чөлөөтэй анхны тогтмол хэвлэл “Ардчилал” сонин 100 мянган хувиар хэвлэгдэн гарснаар чөлөөт хэвлэлийн үндэс суурь тавигдав. Төр засгаас хараат бус “Шинэ толь,” “Ардчилал” сонины араас удалгүй “Үг,” “Үндэсний дэвшил” сонинууд гарч эхэлсэн юм.

100,000 copies of “Ардчилал” (“Democracy”), the first independent newspaper, were printed and distributed on April 7, 1990. This newspaper along with “Shine Toli” (“The New Mirror”) gave a start to freedom of the press in Mongolia. Free press flourished with newspapers “Ug,” “Undesni Devshil” and many others following.





МоАХ, МоАН ардчиллын төлөө шаардлагуудыг амьдралд хэрэгжүүлэх явц удаан байгааг эсэргүүцэж эрх баригчдад тулган шаардах бичиг өгч хариуг 27-нд авахаа мэдэгдсэн юм. Энэ шаардлагад эрх баригчид хариу өгөөгүй тул энэ өдөр засгийн газрын ордныг бүслэн “пикет” гэж алдаршсан цуглаанаа хийв. Эрх баригчид засгийн газрын ордныг цэргээр хамгаалуулсан нь тайван замаар өрнөж байсан ардчилсан хувьсгалд томоохон сорилт болсон юм.

The MDU and MDP were dissatisfied with the slow implementation of pro-democracy measures and petitioned the government for a response by April 27. Not receiving any reply, protesters circled the Government House. Here the peaceful process of democratic revolution faced a serious challenge when authorities decided to deploy military to protect the Government House.



Ардчилсан хувьсгалын дууч, “Хонх” хамтлагийн ахлагч, сэтгүүлч С.Цогтсайхан 4 сарын 27-ны цуглаан дээр.

Singer of the Democracy song, journalist S.Tsogtsaikhan among protesters on April 27, 1990.

Мөргөлдөөнөөс сэргийлэх, цугласан олон арван мянган хүний түрэлтийг зогсоохын тулд МоАХ-ны удирдлага хүмүүсийг урагшаа дайралгүй дороо суухыг уриалж байв.

It took significant effort for democracy activists to keep the crowd under control and prevent clashes between the army and citizens.







Халз тулгаралт зохион байгуулагчдын ихээхэн хүчин зүтгэлийн үр дүнд тайвнаар төгссөн юм.

Despite the tension, the situation finally ended peacefully.



Хилийн цэргийн болон цагдан сэргийлэхийн сургуулийн сонсогчдыг хамгаалалтад гаргасан байлаа.

Border and police academy cadets were mobilized for the security of the Government House.

Хурцадмал байдал намжиж засгийн газар ордныг хамгаалуулсан цэрэг, цагдаагаа татаж авсны дараа цуглаанд оролцогчид тарсан юм. С.Зориг, Б.Галсандорж, Ц.Элбэгдорж нар цуглаанд оролцогчидтой уулзаж байна.

The confrontation eased and the government withdrew the police and military. MDU leaders S.Zorig, B.Galsandorj and Ts.Elbegdorj talking to the crowd.





Хуран цугласан олон арван мянган хүний давалгаа үүсэж биенээ шахаж дарах, эрчээрээ урагшлан цэрэг, цагдаатай мөргөлдөх аюул үүссэн тул С.Зориг "Биднийг дэмжиж байгаа нь суугаарай" гэдэг алдарт үгээ хэлж олон түмнийг тайвшруулж чадсан юм.

A crowd of tens of thousands of people was forcing its way towards the Government House threatening to cause a stampede and crush those in the first rows. S.Zorig shouted his famous phrase "If you support us, please sit down!" and thus was able to cool down emotions of protesters.



Нийслэлд засгийн газрын ордны дэргэд хурцадмал байдал үүсч байх үед алс Хөвсгөл аймагт томиллолтоор ажиллахаар очсон МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүдийг орон нутгийн удирдлагын шийдвэрээр баривчилж хорив. Энэ балмад үйлдлийг эсэргүүцэн тус аймгийн МоАХ-ны салбар зөвлөлийн гишүүд улс төрийн өлсгөлөн зарласан нь ардчилсан хувьсгалын түүхэнд “Хөвсгөлийн улс төрийн өлсгөлөн” гэж алдаршсан юм.

While Ulaanbaatar was on alert, some members of the MDU Council who went to the remote province of Huvsgul to promote democratic ideas were arrested by local authorities. In response, local MDU members staged a political protest known as the “Huvsgul hunger strike.”

МоАХ нэгэнтээ үндэсний хэмжээний улс төр-олон нийтийн байгууллага болсон тул орон даяар эсэргүүцлийн хөдөлгөөн эрчимтэй өрнүүлээ. Бараг бүх аймаг, хот, сумын төвүүдэд цуглаан, суугаа эсэргүүцэл зохион байгуулж эхлэв. Нэлээд хэдэн аймагт улс төрийн өлсгөлөн зарлах тэмцэл эхэлж, их дээд сургуулиудын оюутнууд хичээл хаяж суугаа эсэргүүцэлд нэгдэж байв. МоАХ, МоАН-ын удирдлага гишүүдийнхээ эрх ашгийг тууштай хамгаалж тэдний тэмцлийг газар дээр нь очиж дэмжиж байв.

The MDU had become a nationwide phenomenon. Rallies and sit-ins were held almost in every province and city around the country.





Улс төрийн намууд яриа хэлэлцээ хийж зөвшилцөлд хүрсний үр дүнд Хөвсгөлд 9 өдөр найман шөнө үргэлжилсэн МоАХ, МоАН-ын 18 гишүүн оролцсон энэ тэмцэл 5 дугаар сарын 5-нд зогссон юм. МоАХ, МоАН-ын улс төрийн өлсгөлөн зарласан гишүүд Ард Түмний Онц Зөвлөл байгуулах шаардлага татан авч, АИХ-ын Тэргүүлэгчид цуглаан жагсаалыг хориглосон 86 дугаар зарлигийнхаа зарим заалтыг хүчингүй болгож, Мөрөн хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн гаргасан баривчлах, торгох тогтоолыг хүчингүй болгох тохиролцоонд хүрчээ. 5 дугаар сарын 10-нд болох АИХ-ын чуулганаар Намуудын тухай хуулийг баталж, 18-20 насны залуучуудын сонгогдох эрхийг сэргээх зөвшилцөлд хүрэв.

Negotiations between political parties reached consensus and the 18 Huvsgul hunger strikers from MDU and MDP ended their strike on May 5, 1990 after nine days and eight nights. Pro-democracy forces withdrew Huvsgul's demand for the creation of People's Supreme Council in exchange for cancellation of the arrest and imposition of fines decreed by local government. Other agreements reached were the adoption of the Political Parties Law and lowering the minimum age for election candidates to 18.



Цуглаанд оролцож буй аав хүү хоёр төрийн далбаагаа барьсан нь эе звийн бэлгэдэл болж байлаа.

Father and son holding Mongolia flag symbolized peace and unity.



1990 оны 5 дугаар сар гэхэд МоАН-аас гадна, МСДН, Монголын чөлөөт хөдөлмөрийн нам, МҮДН зэрэг улс төрийн намууд шинээр үүсэн байгуулагдаад байв. Тэдгээрээс Монголын социал демократ намын анхдугаар их хурал 3 дугаар сарын 31-нд, МҮДН-ынх 5 дугаар сарын 13-нд хуралдлаа.

By May 1990, other new political parties emerged. The Mongolian Social Democratic Party (MSDP) held its first Convention on March 31, and the Mongolian National Progressive Party (MNPP) – on May 13.





Шинээр батлагдсан улс төрийн намуудын тухай хуулийн дагуу Дээд шүүх намуудыг дараах дарааллаар бүртгэж авав. 5 сарын 16-нд МАХН, 22-нд МҮДН, 23-нд МЧХН, 24-нд МоАН, 25-нд МСДН, 26-нд МНН тус тус бүртгүүлжээ. МоАН-ын төлөөлөгчид намаа бүртгүүлсний дараа. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэд байгуулсан улс төрийн бүх намыг оролцуулсан Улс төрийн зөвлөлдөх зөвлөлд МоАН-аас Д.Дорлигжав, Б.Галсандорж нар орж ажилласан юм.

MDP representatives after registering their party with the Supreme Court of Mongolia.

According to the newly passed Political Parties Law, parties were registered in the following order: MPRP-May 16, MNPP-May 22, MFLP-May 23, MDP-May 24, MSDP-May 25, and MGP-May 26.

МСДН-ын дарга Б.Батбаяр намаа бүртгүүлээд гэрчилгээгээ авч байна. Энэ үеийн онцлог нь сонгуулийг 7 дугаар сард явуулахдаа шинээр бүртгэгдсэн бүх намуудыг оролцуулах, Ардын түр хурлын оронд Улсын Бага Хурал байгуулах, сонгуулийн комиссын бүрэлдэхүүн зэрэг хэд хэдэн асуудлаар улс төрийн намууд зөвшилд хүрсэн явдал байлаа.

Chairman of the MSDP B.Batbayar (known as Baabar) receiving his party's registration certificate. In accordance with the negotiations, all registered parties were made eligible to participate in the July elections, which would set up a full-time parliament, and the composition of the Elections Commission was agreed upon.





МҮДН-ын төлөөлөгчид улс төрийн намаа бүртгүүлж гэрчилгээ хүлээн авах хуралдаан дээр.

MNPP representatives registering their party with the Supreme Court of Mongolia.

Шинэ намуудын сурталчилгаанд “Ардчилал,” “Шинэ Толь,” “Үндэсний дэвшил,” “Үг” зэрэг төр засгийн хяналтаас чөлөөтэй долоо хоног тутмын шинэ сонинууд чухал үүрэг гүйцэтгэж байсан юм. “Шинэ Толь” сонины шинэ дугаар тарааж яваа бүсгүй.

The main campaign tool for new parties was new independent newspapers-“Democracy,” “New Mirror,” “Nation’s Progress,” and “Word”. Here, a young activist distributes the “New Mirror” weekly paper.







Монголчууд анхны чөлөөт ардчилсан сонгуульдаа урам зоригтой оролцсон билээ. Энэ сонгууль нэг ёсондоо ардчиллын анхны хичээл болсон юм. Сурталчилгааны зурагт хуудсууд наасан "Ардчилал" сонины мухлаг.

Campaign posters, shown here on a "Democracy" newspaper stand, were one of the first visible symbols of Mongolians exercising their democratic rights in the first free and fair elections.

МСДН-ын нэр дэвшигч П.Улаанхүү ба жаалхүү хоёр сонгуулийн сурталчилгааны үеэр. Энэ хоёр бол монгол орны өнөөг ба ирээдүйг цогцлоон бүтээгч хүмүүсийн төлөөлөл юм.

MSDP candidate P.Ulaankhuu and a little boy in his campaign bus-symbols of present and future Mongolia.





Урьд өмнө ийм үйл явдал болж байгаагүй учраас сонгуулийн сурталчилгаа хүмүүст маш сонирхолтой, сонин үзэгдэл байлаа. Ялангуяа, улс төрийн шинэ намуудын мөрийн хөтөлбөрийг нийт сонгогчид ихэд сонирхож, бас гайхаж эргэлзэх маягаар хүлээн авч байлаа.

Election campaigns were a new thing for Mongolians. They were especially curious about what election platforms new parties would offer.



Эрх баригч МАХН улсынхаа бүх машин тэрэг, сонин хэвлэлийг өмчилж сурталчилгаа хийж байхад МоАН, МоАХ нь хандивын мөнгөөрөө худалдан авсан цорын ганц автобусаараа сурталчилгаа хийж байсан юм. Гэсэн ч энэ автобусаараа очсон газар бүрдээ шинэ санаа, шинэ үзэл бодол түгээж байв.

While the ruling party had existing resources and the state run media at its disposal, MDP and other new parties had only a single campaign bus bought with the donation money. But wherever it went it spread new ideas and new thoughts.

МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг сонгуулийн сурталчилгааны үеэр сонгогчидтой тогтмол уулзалт хийж байв.

MDP General Coordinator S.Zorig regularly met with voters during the election campaign.





БНМАУ-ын АИХ-ыг сонгох анхны чөлөөт ардчилсан сонгууль 1990 оны 7 дугаар сарын 22-29-нд боллоо. Монголчууд анх удаагаа оролцохгүй бол шийтгүүлнэ гэсэн айдас хүйдэсгүйгээр олон намаас нэр дэвшсэн олон хүнээс нэгийг нь сонгохоор саналаа өглөө.

The first free and fair elections to the People's Great Hural were held on July 22-29, 1990. For the first time voters had multiple-party candidates to choose from. Here, a rural polling center is visited by nomads.



Анхны чөлөөт ардчилсан сонгуульдаа сонгогчид идэвхтэй, баяртай оролцож анх удаагаа төрийн түшээдээ бие даан сонголоо.

Mongolians of all generations and from all areas of the country actively participated in the new electoral process.





Анхны ардчилсан сонгуулийн дүн гарахад сонгогчдын 61,74 хувь нь МАХН-г дэмжсэн дүн гарчээ. Анхны санал хураалтаар сонгуулийн 430 тойргоос 402 депутат сонгогдсон юм. Үлдсэн 28 тойрогт дахин санал хураалт явуулж эцсийн дүн гарахад МАХН 343, МоАН 23, МҮАН 7, МСДН 4, Монголын чөлөөт хөдөлмөрийн нам 1 суудал авч, 51 хүн нам бусчуудаас нэр дэвшин сонгогдсон байна.

When ballots were counted MPRP received 61.74% of votes, but new parties also joined the State Great Hural. Seats won in the State Great Hural were as follows: MPRP-343, MDP-23, MNPP-7, MSDP-4, MFLP-1 and 51 to non-party MPs.



Ардын Их Хурлын сонгуулийг олон намын оролцоотой мажоритар зарчмаар, Улсын Бага Хурлыг Ардын Их Хурлын депутатууд пропорциональ зарчмаар сонгохоор тогтсон нь шинэ сонгуулийн онцлог байв. АИХ-ын чуулганаас байнгын ажиллагаатай парламент Улсын Бага Хурлыг сонгож баталсан юм. Энэ чуулган БНМАУ-ын Ерөнхий сайдаар Д.Бямбасүрэнг батлав. МҮАН-ын дарга Д.Ганболдыг тэргүүн шадар сайд, МоАН-ын Улс төрийн Зөвлөлдөх төвийн гишүүн Д.Дорлигжавыг шадар сайдаар томилов.

Specific features of the People's Great Hural elections were that the upper house was elected using plurality system, but State Small Hural (lower house) was elected by upper house members using proportional representation of votes received by political parties. At the first session of the State Great Hural D.Byambasuren (MPRP) was appointed as Prime Minister of Mongolian People's Republic. First deputy Da.Ganbold (MNPP) and deputy D.Dorligjav (MDP) were also appointed.

Байнгын ажиллагаатай анхны парламент болох Улсын Бага Хурлын 50 суудлаас МАХН 31, МоАН 13, МҮДН, МСДН тус бүр гурван суудал авчээ. УБХ шинэ Үндсэн хууль боловсруулах зорилгоо амжилттай биелүүлж, ардчилал, зах зээлд шилжих шилжилтийн эрх зүйн орчинг бүрдүүлсэн билээ. УБХ-ын гишүүд.

The first session of the State Great Hural formed State Small Hural (full time legislature) consisting of 50 members (MPRP-31, MDP-13, MNPP-3, MSDP-3).





АИХ-ын чуулган байнгын ажиллагаатай парламент Улсын Бага Хурлыг байгуулж даргаар нь Р.Гончигдоржийг, орлогч даргаар К.Зардыхан, нарийн бичгийн даргаар Б.Чимид нарыг сонгож баталсан юм.

The People's Great Hural elected R.Gonchigdorj as the Chairman of the State Small Hural, K.Zardykhan as the Deputy Chairman and B.Chimid as the Secretary of this full-time legislature.

Анхны чөлөөт ардчилсан сонгуулийн үр дүнд сонгогдсон БНМАУ-ын АИХ –ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1990 оны 9 дүгээр сарын 3-9-нд чуулж БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчөөр П.Очирбатыг сонгосон юм. Ийнхүү монголын тэр анх удаагаа Ерөнхийлөгчтэй болов.

The first session of People's Great Hural convened on September 3-9, 1990 and elected the first President of Mongolia – P.Ochirbat.







АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жэймс Бэйкер 1990 оны 8 дугаар сарын 2 –нд БНМАУ-д айлчлав. АНУ-ын Засаг захиргаа Монголын улс төрийн ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг цаашид ч дэмжинэ гэдгийг нотлоод БНМАУ-ын төрийн тэргүүнийг АНУ-д айлчлуулахаар хоёр тал санал нэгджээ. Түүнчлэн Монголын хувьд АНУ гурав дахь хөршийн зиндаанд байж болох тухай санааг Ж.Бэйкер илэрхийлсэн юм.

US Secretary of State James Baker visited Mongolia on August 2, 1990. The US Government expressed its continuous support for Mongolia's transition to political democracy and market economy. During the visit, it was agreed that the President of Mongolia would visit the United States. James Baker remarked that the US could become a third neighbour of Mongolia.

УБХ-аас Өмч хувьчлах тухай хуулийг 1991 оны 6 дугаар сарын 7-нд баталснаар улсын мэдэлд байсан өмчийг хувьчилж эхэллээ. Энэ ажлын хүрээнд цэнхэр тасалбар буюу хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр үйлдвэрийн газруудыг, бага хувьчлал буюу ягаан тасалбараар худалдаа нийтийн хоол, үйлчилгээний бусад цэг салбар жижиг цехийг хувьчилж, хөдөө аж ахуйн нэгдлийн хувьчлалаар малыг малчдад буцаан олгов.

A law on privatization was passed on June 7, 1991. State owned property rights were given to people who received equal number of vouchers-blue colored for buying shares of factories and pink colored for trade and service entities. Herders cooperatives were privatized and livestock returned back to herders.





1991 оны 5 дугаар сарын 21. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 204 дүгээр тогтоолоор “Хувийн хэргээр гадаадад явах журмын тухай заавар” батлав. Мөн “БНМАУ-ын үндэсний гадаад паспортыг олгох журам” баталж 6 дугаар сарын 1 –нээс мөрдөж эхлэхийг ГХЯ, ЦЕГ, УАБХЕГ-т даалгав. Ингэснээр Монголчууд гадаадад чөлөөтэй зорчих эрхтэй болов.

The Council of Ministers (cabinet) issued decree No.204 in May 1990 titled “Rules on traveling abroad for private matters” and adopted rules on national foreign passport. For the first time in 70 years, Mongolians enjoyed the freedom to travel abroad.



БНМАУ-ын АИХ-ын чуулган 70 хоног хуралдаж 1992 оны 1 дүгээр сарын 13-нд шинэ Үндсэн Хуулиа баталж улсынхаа нэрийг МОНГОЛ УЛС болгов. Монголд хүний эрх улс төр, эдийн засаг, оюун санааны эрх чөлөөг шинэ ардчилсан үндсэн хуулиар тунхаглав. Шинэ Үндсэн хуулиа баталснаар нийгмийн тогтолцоогоо бүхэлд нь халж ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үе эхэллээ.

The People’s Great Hural held a full session (70 days) and adopted the new Constitution of Mongolia on January 13, 1992. The name of the country was changed from People’s Republic of Mongolia to Mongolia. The New Constitution guaranteed the people of Mongolia human rights, political and economic freedoms, and freedom of expression. The legal foundation for the transition of Mongolia to democracy and market economy was established.



БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат 1991 оны 1 дүгээр сарын 22-24-нд АНУ-д айлчлал хийж Ерөнхийлөгч Ж.Буштай хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчмын асуудлаар санал солилцов. Энэ айлчлал нь Монголын төрийн тэргүүний АНУ-д хийсэн анхны айлчлал юм. Айлчлалын дараа АНУ-ын Конгрессын хоёр танхим Монголын ардчилал шинэчлэлийг дэмжсэн тогтоол гаргасан билээ.

On January 22-24, 1991, in Washington, the first American-Mongolian summit was successfully held: President of Mongolia Punsalmaagiin Ochirbat and US President George Bush, reached basic agreements on the chief directions for future development of relations. Shortly after the first visit to US by Mongolian President both Houses of the US Congress, in a joint session made an unprecedented resolution in support of the US policy, “to provide maximum assistance to Mongolian reconstruction.”

## **ЗАРИМ ЧУХАЛ ҮЙЛ ЯВДЛУУД**

### **SOME IMPORTANT DEVELOPMENTS IN 1991**

- 1991 оны 2 дугаар сарын 14. АНУ болон өндөр хөгжилтэй улсууд идэвхтэй дэмжсэний үр дүнд манай улсыг Олон улсын Валютын сан, Дэлхийн банкны гишүүнээр элсүүлэн авав.
- On February 14, 1991, with active support of US and developed countries, Mongolia became a member of the International Monetary Fund and the World Bank.
- 1991 оны 8 дугаар сарын 13-14. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн урилгаар Японы Ерөнхий сайд Тошику Кайфу гэргийн хамт айлчлав. Т.Кайфу Монголын өөрчлөлт шинэчлэлийг дэмжихээ илэрхийлж 2 тэрбум иений буцалтгүй тусламж үзүүлэх, Токиод Монголыг дэмжигч улсуудын зөвлөлгөөнийг хийх болсноо мэдэгджээ.
- Prime Minister of Japan Toshiku Kaifu visited Mongolia on August 13-14, 1991. He reiterated support for Mongolia's democratic reforms and announced that Japan would provide 2 billion yen to support Mongolia and organize a donor countries conference in Tokyo.
- 1991 оны 9 дүгээр сарын 5-6. Хандивлагчдын анхны зөвлөлдөх уулзалт Токио хотод болж Монголд туслах хандивлагчдын бүлэглэл бүрдэх үндэс тавигдав. ЗХУ-аас үзүүлж байсан зээл тусламж зогссон хүнд үед эдгээр орноос үзүүлсэн зээл буцалтгүй тусламж нь шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад үнэлж баршгүй чухал үүрэг гүйцэтгэсэн юм.
- The first conference of Mongolia donor countries was held in Tokyo on September 5-6, 1991. Their subsequent loans and aid played a vital role as timely support to overcome hardships of Mongolia's economic transition as the country was beginning to suffer from withdrawal of subsidies from the Soviet Union.

